



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 05 өдөр

Дугаар А/808

Булган сум

Барилга байгууламжийг ашиглалтад оруулж, өмч бүртгэл бүртгэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1, 35.1.4, 35.1.6, 48 дугаар зүйл 48.1.8, 49 дүгээр зүйлийн 49.3, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2, 28 дугаар зүйлийн 28.1, 28.2, 34 дүгээр зүйлийн 34.1, Засгийн газрын 2017 оны 353 дугаар тогтоолоор баталсан “Барилга байгууламжийн ашиглалтын дүрэм батлах тухай” дүрэм, 2021 оны 212 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах тухай дүрэм”-ийн 4.2, 8.7, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 49 дүгээр “Журам батлах тухай” тушаалын 1 дүгээр хавсралтын 4.1, Булган аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн А/803 дугаар “Эрх олгох тухай” захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган аймгийн хэмжээнд Улс, орон нутаг, гадаадын зээл тусламж, хувийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн барилга байгууламж, авто замын угсралт, өргөтгөл, шинэчлэл, засвар, тохижилтын ажлыг зөвшөөрөл, зураг төслийн дагуу гүйцэтгэснийг баталгаажуулж ашиглалтад оруулах улсын комиссын дүгнэлт баталгаажсан өдрөөс ажлын 5 өдөрт багтаан аймаг Засаг даргад нэг хувь материалыг хүргүүлж ажиллахыг Газрын харилцаа, барилга хот, байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т үүрэг болгосугай.

2. Барилга байгууламж, авто замын угсралт, өргөтгөл, шинэчлэл, засвар, тохижилтын ажлын нэг хувь материалыг орон нутгийн өмчийн газарт хүргүүлж, өмч бүртгэл бүртгэлд бүртгэж авах ажлыг зохион байгуулахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн), Орон нутгийн өмчийн газар (Т.Баттулга), ашиглагч байгууллагын удирдлага, гүйцэтгэгч нарт тус тус даалгасугай.

3. Ашиглалтад оруулсан барилга байгууламжийн дүгнэлт баталгаажсан өдрөөс эхлэн Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3, 14.6 дахь заалтын хугацаанд гарсан зөрчлийг захиалагч, зураг төсөл зохиогч, гүйцэтгэгч, материал ханган нийлүүлэгч, эзэмшигчийн аль буруутай этгээдээр хохирлыг барагдуулж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн), ашиглагч нарт тус тус үүрэг болгосугай.

4. Барилга байгууламж шинээр барьсан, өргөтгөх, шинэчлэх, засварлах, тоноглох ажил нь ашиглалтын шаардлага хангасан бол холбогдох хууль, дүрэм журмын дагуу гэрчилгээ олгож ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т үүрэг болгосугай.

5.Ашиглалтад оруулсан барилга байгууламжийн баримт материалыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зөвхөн эх хувиар нь хүлээн авч архивын нэгж үүсгэн хадгалахыг Төрийн архив (Д.Батсайхан)-т зөвшөөрсүгэй.

6.Барилга байгууламжийн ашиглалтын дүрэм дүрмийг чанд мөрдөж, байгууламжид дур мэдэн өөрчлөлт хийх, ашиглалтын горимыг зөрчихгүй ашиглахыг ашиглагч байгууллагын удирдлагад үүрэг болгосугай.

7.Энэхүү захирамжийн хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Г.Давааням)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Б.АРИУН-ЭРДЭНЭ